



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА П.АЛТАНГЭРЭЛ ТАНАА**

2013-02-26 № *01/68407-107/2013/31/27А-01113*
Улсын төсвийн орлого болгох тухай.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараахь зөрчил илэрлээ.

Соёл, спорт, аялал жуулчлалын яам нь Эзэн Чингэсийн 850 жилийн ойд зориулсан баярын урлагын арга хэмжээний кассаар зарагдсан 200 ширхэг билетний үнэ 3.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэлгүй “Туургатан язгуур” ТББ-д тушаал шийдвэр эрх зүйн актгүйгээр олгосон байна. Энэ Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “ Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1-т “Төрийн өмчийн байр, эд хөрөнгийг ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсвэл төвлөрүүлээгүй зөрчилд төрийн аудитын байгууллага акт тавина” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1 “Туурагтан язгуур” ТББ-д олгосон билетний үнэ 3.0 сая төгрөгийг төгрөгийг улсын төсвийн орлого болгож, Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 90000601 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Дээрх 4 дүгээр сарын 1-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн дарга П.Алтангэрэл, нягтлан бодогч Р.Алтантуяа нарт хариуцуулав

АКТЫГ

ТОГТООСОН:
ҮАГ-ЫН АУДИТОР
Ш.Ичинхорлоо
Ш.ИЧИНХОРЛОО
УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

ССАЖЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН
ДАРГА *П.Алтангэрэл* П.АЛТАНГЭРЭЛ
НЯГТЛАН БОДОГЧ *Р.Алтантуяа*

070021